

# 技能実習生の友

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2023 оны 4 дүгээр сар,  
Хаврын дугаар

## Сэдэв

Манганаас мэдэж авцгаая. Японы соёл “Унадаг дугуй унахдаа замын хөдөлгөөний дүрмийг баримталцгаая.”

◇ Ур чадварын дадлагажигч жирэмсэлсэн тохиолдолд...?

◇ Борооны улирал “цүюү” -Хэрхэн өнгөрөөх ба анхаарах зүйлс-  
Хэлний ой “Бяцхан үг”

### Манганаас мэдэж авцгаая. Японы соёл

— Унадаг дугуй унахдаа замын хөдөлгөөний дүрмийг баримталцгаая. —



#### Зөв хариу нь... Бүгд буруу унаж байна!

- 1 Гар утсаар ярингаа унадаг дугуй унах нь аюултай.
- 2 Унадаг дугуйгаар явахдаа зүүн гар талаа баримталцгаая.
- 3 Шүхэр барьж унадаг дугуй унах нь, өмнөх замаа харах боломжгүй тул маш аюултай.
- 4 Хүн сундалж унахаа больцгооё.
- 5 Зэрэгцэн явж, хоорондоо ярингаа унадаг дугуй унах нь замаар зорчих бусад зорчигчдод саад учруулна.

Ур чадварын дадлагажигч та бүхний дотор унадаг дугуй унадаг хүн олон байгаа гэж бодож байна. Та бүхний өөрсдийнхөө аюулгүй байдлын төлөө ч гэсэн, мөн явган зорчигч зэрэг бусдыг гэмтээж бэртээхгүйн тулд ч гэсэн унадаг дугуй унахдаа замын хөдөлгөөний дүрмийг баримталцгаая.

JITCO сурах бичгийн онлайн дэлгүүрт DVD “Q&A-аар тогтоох Японы замын хөдөлгөөний аюулгүй байдал-Явган зорчигчид болон унадаг дугуйны дүрэм”-ийг худалдаалж байна. Мөн, шинээр үүсгэсэн “JITCO электрон сурах бичгийн сайт”-аар ч төлбөртэй дүрс бичлэгийг цацаж байна.

“Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-ийг Ур чадварын дадлагажигч, суралцагчдад зориулан Япон дахь өдөр тутмын амьдралд хэрэг болох мэдээлэл болон Япон хэлний сургалтын материал, 4 нүхт манга зэргийг дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи хэл) дээр нийтэлдэг. Та бүхнийг сонирхон ашиглахыг урьж байна!



## Ур чадварын дадлагажигч жирэмсэлсэн тохиолдолд...?

2022 оны 12-р сард Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (ОТИТ)-гаас нийтэд дэлгэсэн материалаас үзвэл, Ур чадварын дадлагажигчдаас асуухад, “Жирэмслэлт, төрөлтийг шалтгаан болгож хохирол учруулахыг хориглосон байдаг талаар тайлбар авсан бөгөөд мэддэг” гэж хариулсан Ур чадварын дадлагажигч 60% орчим байсан. Нөгөөтэйгөөр, Ур чадварын дадлагажигчдын ойролцоогоор 4 хүний 1 нь, ялангуяа Илгээгч байгууллага нь “Жирэмсэлсэн тохиолдолд дадлагыг үргэлжлүүлэх боломжгүй” гэх мэтээр хэлсэн тохиолдол бий гэж хариулж байна. Японд ажил эрхлэгч (Ур чадварын дадлагажигч орно.)-ийг жирэмсэлснийг нь шалтгаан болгож ажлаас халахыг хуулиар хориглодог.

Ур чадварын дадлагажигч та бүхэн жирэмсэлснээ мэдвэл яах хэрэгтэй талаар энд ерөнхий тайлбарлая.

### Q: Жирэмсэлсэн тохиолдолд яах хэрэгтэй вэ?

- Эх барих, эмэгтэйчүүдийн тасагт үзүүлээрэй.
- Компанийхаа болон Хянан зохицуулагч байгууллагын хүнтэй зөвлөж ярилцаарай.
- Хот, дүүрэг, суурин, тосгоныхоо захиргааны газарт очин, “Жирэмсэлсний мэдэгдэл” гаргаж бүртгүүлээрэй.



### Q: Ур чадварын дадлага юу болох вэ?

- Ур чадварын дадлагажигчийн жирэмсэлснийг нь шалтгаан болгож, Хянан зохицуулагч байгууллага болон Дадлагыг хэрэгжүүлэгч этгээд ур чадварын дадлагыг нь болиулах эрхгүй.
- Хүсэлт гаргавал, амаржихын өмнө төрөхөөр тодорхойлогдсон өдрөөс 6 долоо хоногийн өмнөөс ажлаасаа чөлөө авах боломжтой. Мөн, Японд амаржсаны дараа эхийн биеийн эрүүл мэндийг хамгаалахын тулд амаржсаны дараагийн өдрөөс хойш зарчмын хувьд 8 долоо хоног ажил эрхэлж болохгүй. Ажил

эрхлэхгүй байх хугацааны цалин нь тухайн компаний журмаас хамаарах ба цалин олгогдохгүй тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас “Төрөлтийн тэтгэмж (хөдөлмөрийн хөлсний 60 орчим хувь)” олгогдоно.

- Хүсэлт гаргавал, ур чадварын дадлагаасаа чөлөө авч, түр хугацаагаар нутаг буцаж амаржин, амаржсаныхаа дараа ур чадварын дадлагаа дахин эхлүүлж ч болно. Хянан зохицуулагч байгууллага болон компанийхаа хүнтэй зөвлөж ярилцаарай.
- Болзол хангавал, хүүхэд асрах амралтын тогтолцоог ашиглах ч боломжтой. Мөн, эрүүл мэндийн даатгалын “Амаржих, хүүхэд асрах нэг удаагийн тэтгэмж”-ийн тогтолцоо ч байдаг.

### Q: Зөвлөгөө өгөх цонхны талаар?

Жирэмсэлснээ мэдвэл, юуны өмнө компанийхаа болон Хянан зохицуулагч байгууллагын г.м ойрын хүмүүстэйгээ зөвлөж ярилцаарай. Ур чадварын дадлагыг үргэлжлүүлэх болон түр хугацаагаар нутаг буцах, жирэмслэлт, төрөлттэй холбогдох процедур, эмнэлэгт үзүүлэх, төрүүлсэн тохиолдолд хүүхдийн оршин суух зөвшөөрөл гэх зэргийн талаар зохицуулах шаардлагатай.



Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (ОТИТ)-д ч “Зөвлөгөө өгөх цонх” байдаг.

Утас: 0120-250-147

Мягмар, Пүрэв (11:00-19:00)

Бямба (9:00-17:00)

Онлайн бөглөх хуудсыг 24 цагийн турш хүлээн авна.

[https://www.otit.go.jp/notebook\\_mn/](https://www.otit.go.jp/notebook_mn/)



Жирэмсэлснээ мэдвэл ганцаараа шаналалгүйгээр, эртхэн партнер болон гэр бүл, компани, Хянан зохицуулагч байгууллага, ОТИТ, албан ёсны зөвлөгөө өгөх цонх зэрэгтэй зөвлөж ярилцаарай. Жирэмслэлт, төрөлт нь таны ирээдүйд маш ихээр нөлөө үзүүлэх үйл явдал тул, хүний ээж болохоо ухамсарлаж, хариуцлагатай үйлдэл хийх хэрэгтэй.

### <Нэмэлт мэдээлэл>

Ур чадварын дадлагажигч нарт зориулсан гарын авлагад ч жирэмслэлт, төрөлтийн талаар дурьдсан байгаа. Мөн, Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын Гадаадын иргэдийн ахуй амьдралыг дэмжих портал сайтад нийтлэгдсэн “Япон улсад ажиллаж амьдрах гарын авлага”-д төрөлт, хүүхэд асрахаас гадна Японы амьдралын талаарх төрөл бүрийн зүйлсийн талаар “Анхан шатны Япон хэл” болон гадаадын 13 хэлээр мэдээлэл оруулсан байгаа.

Үүнээс гадна, мужууд болон хот, дүүрэг, суурин, тосгонд ч гадаадын иргэдэд зориулсан Зөвлөгөө өгөх цонх байдаг.



## Борооны улирал “цүүюү” -Хэрхэн өнгөрөөх ба анхаарах зүйлс-



Японы Хоккайдо болон Тоохоку бүсийн зарим нутгаас бусад нутгуудад 5-р сарын сүүлч үеэс эхлэн 7-р сарын эхэн юм уу дунд үе хүртэл борооны улирал болдог. Энэ борооны улирлыг “цүүюү” гэдэг ба бүрхэг юм уу бороотой өдөр үргэлжилдэг. Цүүюү үүсгэдэг улирлын борооны фронт нь Японы арлын өмнө зүгээс хойд зүг рүү чиглэн өдөр өдрөөр урагшилдаг ба “цүүюү ири/борооны улирлын эхлэл” болон “цүүюү акэ/борооны улирлын төгсгөл”-ийн өдрийг Японы Цаг уурын агентлагаас мэдээлдэг. Бороо ихтэй энэ үед ердийн үеэс илүү цаг агаарын мэдээнд анхаарал хандуулах хүн олон болдог бололтой. Өдрөөсөө хамааран температурын ялгаа ихтэй, бага зэрэг хүйтэн санагдах өдөр ч байдаг бол чийгшил ихтэй, бүгчим халуун өдөр ч байдаг бөгөөд биеийн эрүүл мэндийг хянахад амаргүй өдрүүд

үргэлжилнэ. Биеийн температурын тохируулалтыг сайн хийж чадахгүй болохоор биеийн байдал тааруу болох тохиолдол ч байдаг тул, төвөгшөөлгүйгээр хувцсаараа тохируулж, нойр, хоол тэжээлээ сайн авч, биеийн хүч тамираа сайн хадгалаарай. Мөн, борооны улиралд хөгз болон нянгийн үржил эрчимждэг тул хоолны хордлого үүсэхэд хялбар улирал юм. Хүнсний материалын хяналтандаа анхаарч, ердийн үеэсээ илүү цэвэр байхыг хичээгээрэй.

Нөгөөтэйгөөр, цүүюүгийн үед ихээр орох бороо нь даланд хуримтлагдаж, агаарын хуурайшилт үргэлжилдэг ид халуун зуны улиралд бидний ундны ус болдог. Мөн, хуримтлагдсан борооны ус нь цагаан будааны тариаланд хэрэглэх газар тариалангийн ус болдог чухал үүрэгтэй ба Япончуудын амьдралд зайлшгүй хэрэгтэй “Тэнгэрийн хишиг хур бороо” юм.

Бороо үргэлжлэхээр уйтгар төрөх хандлагатай байдаг боловч зөвхөн борооны улиралд л байдаг баяр баясгалан ч байдаг. Hydrangea цэцэг нь яг цүүюүгийн үед цэцэглэдэг цэцэг бөгөөд Японы олон нутгуудад Hydrangea цэцгийн алдартай газрууд олон байдаг. Чернилэн ягаан, ягаан өнгийн цэцэг болон ногоон навч нь бороонд норхоор өнгө нь улам тодордог тул бороотой өдөр Hydrangea цэцгийн зураг дарахыг мөн санал болгож байна. Японы цаг уурт дасахгүй дадлагажигч та бүхний хувьд өнгөрөөхөд хэцүү улирал боловч янз бүрийн арга сэдэж, “цүүюү”-г сайхан өнгөрөөгөөрэй.

## Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)



# Ур чадварын дадлагажигч, Энэ сарын зураг



Филиппинээс ирсэн Ур чадварын дадлагажигч нар анх удаа Фүжи уулаар аяллаа. Яманашимужийн “Ошино хаккай” дахь булгийн тунгалаг усанд сэтгэл нь хөдөлжээ! Японы үзэсгэлэнт газруудад очиж үзэх мөрөөдлийн нэг нь биелж, баясгалантайгаар мишээж байна.  
 ※2022 оны 7-р сард нийтлэгдэв.  
 (日本メカニック株式会社)

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.  
 (https://www.jitco.or.jp/ja/days/)



## Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн 31-р уралдааны танилцуулга

JITCO нь 4-р сарын 3 (Даваа)-наас Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд оролцох бүтээлийг хүлээн авна. Бүтээл ирүүлэх цаад хугацаа: 5-р сарын 12 (Баасан). Уралдааны дэлгэрэнгүй удирдамжийг JITCO-гийн цахим хуудас (https://www.jitco.or.jp/), JITCO Япон хэлний сурах бичгийн хироба (талбай) (https://hiroba.jitco.or.jp/) -гийн “Мэдээлэл”-д нийтэлсэн байгаа. Та бүхнийг уралдаанд оролцохыг урьж байна!



## “Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-т нийтлэхийг хүссэн сэдэв байвал бидэнд мэдэгдээрэй!

Энэхүү “Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр” товхимлын талаарх санал, сэтгэгдэл болон нийтлэхийг хүссэн сэдэв, сонирхсон сэдвээ баруун талын маягтаар илгээгээрэй.



◆こくこことえ

「あ」はふと気づいたり、思い出した時に、「ああ」の後には「よかった・そうですか」などが続き、安心したり、納得したりした時に言います。驚いたり、思いついたりした時に、思わず出るのが「あっ」です。

文字とちがって、声に出した音は、高低も調子も、みなそれぞれです。

「ああ、いい気持ち」という時と、「ああ、困った」という時では、声のトーンもちがうでしょう。

目で見る言葉と、耳で聞く言葉。何気ない「ああ」にも、気持ちが表れますね。

“あ/a” нь гэнэт анзаарсан, санасан үед хэлдэг. “ああ/aa”-гийн дараа “よかった/yokatta/ болж болж”, “そうですか/sou desuka/ тийм үү” гэх мэтээр үргэлжлэх ба санаа амарсан, ойлгосон үед хэлдэг. Гайхсан, юм санаанд орсон үед өөрийн эрхгүй амнаас гардаг нь “あっ/ah”. Үсэгтэй адилгүй, хоолойноос гарсан авиа бол чанга сул нь ч, төлөв байдал нь ч тус бүр ялгаатай. “ああ、いい気持ち/aa ii kimochi/aa сайхан байна аа” гэж хэлэх үе болон “ああ、困った/aa komatta/aa хэцүүдлээ” гэж хэлэх үед дуу хоолойны өнгө нь ч өөр байх болов уу. Нүдээр харах үг болон чихээр сонсох үг. Санаандгүй “あ/a”-д ч сэтгэлийн байдал илэрдэг.